

АХБ

# ЖЕНДЭРИЙН ШАЛГУУР ЖАГСААЛТ

(Gender Checklist)



ЭРҮҮЛ МЭНД

## Агуулга

Жагсаалтын зорилго	
Эрүүл мэндийн төслүүдэд жендэрийн асуудал яагаад чухал байдаг вэ?	1
Гол асуудлууд	2
Төслийн хүрээнд анхаарах гол асуудлууд ба үйл ажиллагаа	5
Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн асуудал	7
Нөхөн үржихүйн эрүүл мэндийн жендэрийн асуудлууд	10
Гэр бүл төлөвлөлт дэхь жендэрийн асуудлууд	14
Эрүүл мэндийн тусламж үзүүлэх тогтолцоон дахь асуудлууд	17
Эрүүл мэндийн төслүүдэд дэхь жендэрийн чиг хандлага, стратеги	21
Хавсралт: Жендэрийн мэргэжилтний ажил үүргийн хуваарь	24
Эх сурвалжуудын түүвэр	25

## Товчлол

ХБГО	Хөгжиж буй гишүүн орон
ЖХ	Жендэр ба хөгжил
АНҮ	Анхдагч нийгмийн үнэлгээ
ХҮ	Хяналт, үнэлгээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТБТТ	Төслийн Бэлтгэлийн Техникийн Туслалцаа
ЕЯТЗ	Ерөнхийлөгчид явуулах тайлан ба зөвлөмж
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
АҮХ	Ажил үүргийн хуваарь
ХЭ	Хөгжил дэхь эмэгтэйчүүд

Энэхүү баримт бичгийг олон нийтийн хүртээл болгох зорилгоор монгол хэлнээ хөрвүүлсэн боловч англи хэл нь Азийн хөгжлийн банк (АХБ)-ны албан ёсны хэл тул зөвхөн англи хэл дээрхи эх хувийг нь албан ёсных хэмээн үзнэ. Иймд иш татахдаа англи эхийг ашиглана уу. АХБ орчуулгын үнэн зөв эсэх талаар баталгаа өгөхгүй бөгөөд эх хувиас утга нь гажсан тохиолдолд аливаа хариуцлага хүлээхгүй болно.

## Гарын авлагын зорилго

Азийн Хөгжлийн Банкны Жендэрийн болон Хөгжлийн (ЖХ) бодлого, стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэгч ажилтан, зөвлөхүүдэд энэхүү гарын авлага туслах болно. (1998 оны 5 сард гарсан АХБ-ны Жендэр болон хөгжлийн бодлого гэдгийг үз). Энэ нь эрүүл мэндийн салбарын хөтөлбөр, төслүүдийн бүх үе шатанд жендэрийн талаар анхаарах гол асуудлуудыг тодорхойлж, жендэрийн мэдрэмжтэй стратеги, үзүүлэлтүүдийг боловсруулахад хэрэгчлэгчдэд тусална.

АХБ-ны ажилтнууд Төслийн Бэлтгэлийн Техникийн Тусалцааны \ТБТТ\ үе шатанд анхдагч нийгмийн үнэлгээнд \АНҮ\ жендэрийн асуудлыг хөндөж гаргахад энэ хяналтын хуудсыг ашиглавал зохино. Зөвлөхүүд үүнийг ТБТТ-ны нийгмийн дүн шинжилгээг илүү нарийвчлан гаргахдаа хэрэглэнэ. Гэхдээ энд дурдагдаж байгаа асуудлууд бүх төслүүдэд хамааралтай бус байж болох тул банкны ажилтнууд болон зөвлөхүүд нөхцөл байдалд

тохирсон стратегийг сонгон авч хэрэглэвэл зүйтэй. Эрүүл мэндийн төслүүдэд жендэрийн асуудлыг нэг чиг хандлагатай болгох, эрүүл мэндийн төслүүдэд жендэрийн асуудлыг оруулж амжилттай хэрэгжсэн төслүүдийг жишээ болгон харууллаа.

Төслийн бэлтгэл явцад жендэрийн шалгуур жагсаалтыг АХБ-ны Нийгмийн хэмжигдэхүүнийг төсөлд тусгах гарын авлага \1994\, Хяналт Үнэлгээ хийх удирдамж ба Хөгжлийн асуудалд эмэгтэйчүүдийн оролцооны тойм зэрэг номуудыг ашиглах боломжтой. Бусад хэрэгцээтэй эх сурвалжийн жагсаалтыг товхимолын төгсгөлд дурдсан болно.

Энэхүү жендэрийн шалгуур жагсаалтыг Сюзанне Вендт Ширийн Латийф нар зөвлөх Пенелопын эхэлсэн ажилд үндэслэн бэлтгэсэн бөгөөд Мэри Энн Асико хянан тохиолдуулж, хэвлэлийн эхийг Жун дела Круз бэлтгэсэн. Маривик Гуиллиермо хэвлэлтэнд тусалцаа үзүүлээ.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСЛҮҮДЭД ЖЕНДЭРИЙН АСУУДАЛ ЯАГААД ЧУХАЛ БАЙДАГ ВЭ?

Эмэгтэйчүүд биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн хамгийн дээд зэргийн түвшинд эрхээ эдлэх эрхтэй. Энэ эрхээ эдлэх нь тэдний амьдрал, сайн сайхан байдал, хувийн болон нийгмийн амьдралын бүхий л асуудалд оролцоход чухал ач холбогдолтой. Учир нь эмэгтэйчүүд эрүүл мэндийн асуудалд үйлчлүүлэгч болон асран хамгаалагч байдлаар оролцдог учраас эрүүл мэндийн төсөл хөтөлбөрүүд нь эмэгтэйчүүдийн эрх мэдлийг бэхжүүлэхэд чиглэгдсэн байдаг гэсэн ташаа ойлголт маш түгээмэл. Эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тусламжийн хүртээмж болон түүнийг хэрэглээ, гарч болох эрүүл мэндийн үр дагаварт жендэрийн тэгш бус байдал оршисоор байгаа нь эрүүл мэндийн салбарын шинэчлэлд жендэрийн тэгш эрхэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Хөгжиж байгаа олон оронд нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо муудаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хувьчлахдаа боломжтой эрүүл мэндийн тусламжийг хүртээмж, хамралтын асуудлыг баталгаатай байх оновчтой хувилбарыг сонгоогүйгээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанар буурч ирсэн. Энэ байдал нь охид эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд шууд нөлөөлөөд зогсохгүй эмэгтэйчүүдийн хүлээх хариуцлага нь тэгш бус болсон. Гэр бүл, хамт олны дотор тэдний хүлээдэг үүргийг ихэвчлэн хүлээн зөвшөөрдөггүй болохоор тэд нийгэм, сэтгэл зүйн болон эдийн засгийн дэмжлэг авч чаддаггүй.

---

**Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал нь боловсрол, ажлын нөхцөл, амьжиргааны түвшин, нийгмийн болон эдийн засгийн үзүүлэлт зэргээс хамаардаг.**

---

---

**Эрүүл мэндийн төслүүд  
эмэгтэйчүүдийн эрх  
мэдлийг дээшлүүлэхэд  
чиглэгддэг гэсэн ташаа  
ойлголт маш түгээмэл  
байдаг**

---

Ядуу хүний анхдагч хөрөнгө нь хүний өөрийнх нь чадавхи байдаг. Түүнийг хөгжүүлэх нь ядуурлыг бууруулахад үндэс болно. Хүн бүрт эрүүл мэндийн анхны тусламж болон бусад нэн шаардлагатай тусламж хүртээмжтэй байх ёстой. Эдгээр нь хүртээмжгүй бол ядуус болон тэдний

үр хүүхдийн эдийн засгийн байдлыг сайжруулах, нийгмийн амьдралд оролцох боломж нь их хязгаарлагдмал болно. Ядуурал болон жендэрийн асуудал нь сэтгэцийн өвчин, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, эрүүл мэндийн бусад асуудлаас болж эмэгтэйчүүдийг эмзэг байдалд оруулдаг харилцан хамааралтай бөгөөд зарим тохиолдолд бүр нийгмээс гаргадаг ч үр дагавартай. Хэдийгээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон түүний эрүүл мэндийн нөлөө нь нийгмийн бүх бүлэгт түгээмэл байгаа нь зөвхөн ядууралын асуудлыг дангаар нь шийдэх нь хангалтгүй гэдгийг харуулж байна.

Эрүүл мэнд, сайн сайхан байдал нь мөн эрүүл мэндийнхээ төлөө анхаарал тавьдаг хувь хүний соёлоос их хамаардаг бөгөөд ядуу эмэгтэйчүүд охидод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж нь дутмаг байдаг.

## ГОЛ АСУУДЛУУД

АХБ-наас санхүүжүүлсэн эрүүл мэндийн төслүүдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний стратегийг хөхүүлэн дэмжихийг чармайдаг бөгөөд өндөр эрсдэлт хүн ам болох ядуучууд, хүүхэд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд туслалцаа үзүүлэхэд анхаардаг. Эдгээр зарчим нь эмэгтэйчүүдийг оролцуулах, ялангуяа эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн арга хэмжээг төлөвлөх, хүргэхэд идэвхитэй орлцуулахын төлөө байдаг. Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд нь тэдний эдийн засаг, нийгмийн байдлаас хамаардаг. Бусад хүчин зүйлсийн дотор тэдний амьжиргааны түвшин, боловсрол, ажлын нөхцөл зэрэг орно. Эрх болон хамт олны дотор урьдчилан

сэргийлэх, эмчилгээний тусламж үйлчилгээг үзүүлэх, хөгжүүлэхэд эмэгтэйчүүдийн үүргийн талаар бодлого боловсруулагчид хүлээн зөвшөөрөх ёстой. Хөгжлийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийг зөвхөн ашиг хүртэгч байдлаар бус өөрчлөлт хийхэд чухал үүрэгтэй гэдгийг харгалзан үзэх ёстой.

Эмэгтэйчүүдэд чиглэгдэх нэг асуудал бол эх хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг сайжруулах, эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ үзүүлэх үйлчилгээг илүү үр дүнтэй дэмжих явдал байдаг. Энэ чиглэлд төрөхийн өмнөх болон төрсний дараах тусламж үйлчилгээ ба хяналт, гэр бүл төлөвлөлтийн мэдээлэл болон эх сурвалж, БЗХӨ-ний эрсдлийн талаархи мэдээллийг оролцуулан нөхөн үржихүйн эрүүл мэндийн ерөнхий тусламж үйлчилгээний асуудлуудыг багтаадаг. Үйлчилгээ нь мөн дархлаажуулалт, хүүхдийн есөлт, хоол тэжээлийн зөвлөгөө, ариун цэвэр сахих, өвчнөөс сэргийлэх, шингэн уулгах эмчилгээ зэрэг хүүхдийн эрүүл мэндийн асуудлуудыг багтаах ёстой. Хөгжиж байгаа олон оронд эрүүл мэндийн тусламж үзүүлэгч нь эмэгтэй хүн биш, тусламж нь хүртээмжтэй бус, соёл, заншлын хуучирсан арга барилыг дэмжсэн тохиодолд эмэгтэйчүүд, тэдгээрийн хүртэх үйлчилгээ, эсвэл мэдээлэл олж авах, өөрсдийн болон гэр бүлийнхээ эрүүл мэндийг сайжруулах боломж нь хязгаарлагдмал байдаг. Иймд эрүүл мэндийн салбар дахь жендэрийн болон хөгжлийн гол стратеги эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн мэргэжилд сургаж олон нийтэд тулгуурласан эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ гэдэг оролцооны арга ажиллагааг дэмжих явдал юм.

Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ гэсэн чиглэл байгаа хэдий ч эрэгтэйчүүдийг орхигдуулах ёсгүй. Гэр бүл төлөвлөлт, хамт олны зохион байгуулалтад нөөцийг хуваарилах асуудалд эрэгтэйчүүд шийдвэр гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиныг нь гэр бүлийн, нөхөн үржихүйн болон хамт олны эрүүл

---

**Эрүүл мэндийн  
төслүүдэд эмэгтэйчүүд  
эмэгтэйчүүдээ гэдэг  
зарчмыг баримтлах  
боловч эрэгтэйчүүдийн  
асуудлыг бас  
анхаарах ёстой.**

---

Гэр бүлийн болон хамт олны эрүүл мэндийн асуудалд эрэгтэйчүүд эмэгтэйчүүд хариуцлагаа тэнцүү үүрэх зарчмыг дэмжих хэрэгтэй.

мэндийг сайжруулах төслүүдэд бүрэн оролцуулах шаардлагатай. Нийгмийн эрүүл мэндийн үр дүнтэй хөтөлбөрүүд гэр бүлийн, нөхөн үржихүйн болон хамт олны эрүүл мэндийн бүх чиглэлд эрэгтэйчүүдэд чиглэсэн гэр бүлийн хандлагыг эмэгтэйчүүд эмэгтэйчүүддээ гэсэн хандлагатай хамтруулбал зохино.

Хайрцаг 1

### ТБТТ-ны төслийг хэрэгжүүлэх бодит байдлыг судлах үе шатанд АНУ-ний жендэрийн гол асуудлууд

- Төслийн зорилтот хүн амыг тодорхойлох. Хүн амын тоо бримтыг жендэрээр ялгах. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тэдний гүйцэтгэх үүрэг, эдийн засаг, боловсрол, боловсрол, эрүүл мэндийн өөр хоорондоо хэрхэн ялгаатай байдаг талаар харгалзан үзэх
- Хүн амын доторх жижиг бүлгүүдийн хоорондын ялгааг харгалзан үзэх. Тэдгээр бүлгүүд дэх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн байр суурь, гүйцэтгэх үүрэг, аж байдлын ялгааг онцлон харуулах
- Төсөлд хамрагдаж байгаа зорилтот хүн амын бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагыг үнэлэх. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд өөр зорилт, хэрэгцээтэй эсэх,

эдгээр ялгаа нь төсөлд хэрхэн нөлөөлөх

- Чадавхыг үнэлэх. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд төсөлд хэрхэн оролцож байгааг анхаарах-төсөлд хамрагдах хүсэл эрмэлзэл, нөлөөлж буй хүчин зүйл, мэдлэг, ур чадвар, зохион байгуулалтай холбоотой нөөц, түүнчлэн төсөл нь тэдний нийгэм, соёл уламжлалд хэрхэн тохирч байгаа
- Эмэгтэйчүүд, тэдний төсөлд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг Төрийн болоод ТББ-уудыг тодорхойлж хамтран ажиллах

## ТӨСЛИЙН ҮЕД ГАРАХ ГОЛ АСУУДЛУУД БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэхүү шалгуур жагсаалт нь жендэрийн дүн шинжилгээнд үндэслэсэн бөгөөд уян хатан, нөхцөл байдалд тохируулан ашиглах боломжтой. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өрх гэр, хамт олон, нийгэм дэхь байр суурь, үүрэг хариуцлага харилцан адилгүй байдаг болохоор хэрэгцээ, эн тэргүүнд тавих асуудлыг жендэрийн дүн шинжилгээгээр гаргадаг. Жендэрийн ялгавартай тоо баримт мэдээлэл нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэрэгцээ, эн тэргүүнд тавигдах асуудлууд, тэдний мэдлэг, дадлага, үйл ажиллагаа нь төслийн үйл ажиллагаатай хэрхэн уялдах зэргийг тодорхойлоход ач холбогдолтой. Энэхүү мэдээлэл нь төслийн төлөвлөлтөд нөлөөлж, төслийн үр дүн, үр ашигт тустай байдаг. Төслийг хэрэгжүүлэх боломжийг судлах судалгааны явцад жендэрийн дүн шинжилгээнд дээр үндэслэн дараах хоёр асуудлыг авч үздэг. Үүнд:

- ➔ Төслийг хэрэгжүүлэх бодит байдлыг судлах судалгаанд хамрагдах төслийг хэрэгжүүлэх нутагт оршин суугаа эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үүрэг, байр суурийн ялгаа нь төсөлд хэрхэн нөлөөлөх вэ? Төсөл нь тэдгээр ялгаатай үүрэг, байр суурийг хэрхэн авч үзэж, үүнийг төслийн хүрээнд хэрхэн шийдвэрлэх вэ?
- ➔ Эмэгтэйчүүдийн байр суурийг нэмэгдүүлэхэд төслийн стратегийн боломж хэр вэ? Төсөл нь эрэгтэй эмэгтэй хүмүүст хэрхэн нөлөөлөх вэ? Эмэгтэйчүүдийн эрх мэдлийг бэхжүүлэх талаар төсөл ямар урт хугацааны стратегитэй вэ?

Эмэгтэйчүүдийн үүрэг нь тусламж үйлчилгээг хүргэх, урьдчилан сэргийлэх ажилд оролцохоос гадна гэр бүл, нийгмийн бүлгүүдийг эмчлэхэд чиглэгддэг гэдгийг төслийг төлөвлөгч, боловсруулагчид хүлээн зөвшөөрөх ёстой.

Жендэрийн шалгуур жагсаалт нь АНУ-ний (Хайрцаг 1-д нэгтгэн дүгнэсэн) төслийн бэлтгэлийн техникийн туслалцааны баримт цуглуулах үе шатанд болон нийгмийн дүн шинжилгээний (Хайрцаг 2-т нэгтгэн дүгнэсэн) үе шатанд хэрэглэнэ.

Жендэрийн дүн шинжилгээний эцсийн зорилго нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг аль алиныг нь уг төслөөс ашиг хүртэх боломжийг дээд зэргээр нэмэгдүүлэхүйц төслийг төлөвлөх, энэ үйл явцад тэднийг өргөнөөр оролцуулах явдал юм. Энэ нь жендэрийн бусад нэмэлт мэдээллийг ашиглаж төслийг төлөвлөхөд ач тустай.

Жендэрийн дүн шинжилгээг хоёр үе шаттайгаар явуулдаг. Төслийн хүрээнд үйлчлүүлэгч хүн амын жендэрийн ялгавартай шинж байдлыг тухайн төсөл хэрэгжүүлэх газрын нийгэм эдийн засгийн болон соёл, зан заншилтай уялдуулан судалдаг. Энэхүү дүн шинжилгээг төслийг төлөвлөх болон бүх үе шатны үйл ажиллагаанд ашиглана.

## Хайрцаг 2

### ТБТТ-ны Нийгмийн үнэлгээ болон төслийг боловсруулахад анхаарах жендэрийн гол асуудлууд

**Оролцооны арга:** Төслийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд бүхий л үйл явцад эмэгтэйчүүдтэй зөвлөлдөж, тэднийг оролцуулах

#### Жендэрийн дүн шинжилгээ:

- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрхэлдэг үйл ажиллагаа, нөөц боломжийг хүртэх, хянах байдлыг үнэлэх
- Энэхүү мэдээллийг хүн ам зүйн, эдийн засгийн, ёс заншлын, нийгмийн, хууль эрх зүйн болон тогтолцоотой уялдуулан ямар зөрүү ялгаатай байгааг гаргах
- Уг мэдээлэл, дүн шинжилгээг төслийн бүхий л үе шатанд хэрэглэх

#### Мониторинг ба үнэлгээ :

Төслөөс эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд төслийн үр дүнг тэгш хүртэж байгаа гэдгийг харуулсан шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах

#### Нийгмийн үнэлгээ:

Жендэрийн дүн шинжилгээн дээр үндэслэн зорилтот хүн амын бүлгийнхээ хэрэгцээ, шаардлага, чадавхи болон тогтолцоог бий болгож, төслийн эмзэг бүлэгт нөлөөлж байгаа сөрөг нөлөөллийг тогтоох

#### ТББ-уудтай хамтран ажиллах:

Эмэгтэйчүүд болон хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудтай хамтран ажиллах

## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН АСУУДЛУУД

### Гол асуултууд

#### Өрхийн үйл ажиллагаа

- ➔ Үйлчлүүлэгч хүн амын дунд жендэрийн ялгаатай хөдөлмөрийн хуваарь байна уу? Үйлдвэрлэлийн болон нөхөн үржихүйн үүрэг нь (өрхийн хөдөлмөрийн хуваарь нь жендэрийн хувьд хэрхэн ялгаатай байгаа, эд бараа үйлдвэрлэх болон үйлчилгээ, орлогыг эзэмшиж байгаа зэрэг) хэрхэн харилцан холбоотой байна вэ? Мэдээлэл нь хөгшин, залуу, эрэгтэй, эмэгтэй, охид хөвгүүдийн дунд хэрхэн ялгаатай байгааг харуулах ёстой. Өөрөөр хэлбэл, хэн юуг, хаана, яаж, хэзээ, хэр удаан хугацаанд хийж байна вэ гэдгийг харуулах ёстой.
- ➔ Үйлчлүүлэгч хүн амын орлогын түвшин нь ямар байна вэ? Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хооронд орлогын ялгаа байгаа эсэх?
- ➔ Нийгмийн бүтэц болон зохион байгуулалтын (хамт олны зохион байгуулалт, соёл заншлын тухай ойлголт ба хандлага, гэр бүл болох журам, газар эзэмших хэв маяг гэх мэт) гол асуудлуудыг жендэрийн болон нийгэм эдийн засгийн байр сууриар нь ялгаатай тодорхойлох
- ➔ Төслийн хүрээнд ямар үйлчилгээг (эрүүл мэндийн, боловсролын, усны, дэд бүтцийн, хөдөө аж ахуйн, хууль, эрх зүйн) хэнд үзүүлэх вэ? Үүнд нийгэм эдийн засгийн байдлын болон жендэрийн ялгаатай байдлыг харгалзан үзэх.
- ➔ Эмэгтэйчүүдийн эрх зүйн байдал нь ямар байна вэ? Эмэгтэйчүүд өөрсдөө шийдвэр гаргах (жишээ нь гэр бүл салах, өмч эзэмших, гэр бүл салалтын дараа хүүхдээ асран хамгаалах, нөхөн үржихүйн асуудлаар шийдвэр гаргах г.м.) эрхтэй байна уу?
- ➔ Гэр бүлээсээ салсан эмэгтэйг нийгэм нь ялгаварлан гадуурхдаг уу? Жендэрээр ялгаварлан гадуурхах нь ердийн үзэгдэл үү? Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн харилцаа холбоонд хязгаарлалт байдаг уу?

Эмэгтэйчүүд эрүүл мэндийн тусламж үзүүлдэг эрэгтэй хүнд хандахдаа дургүйцдэг үү?

### Төсөлд хамрагдаж байгаа хүн амын эрүүл мэндийн байдал

- Төслийн хэрэгжих газар ямар өвчлөл хамгийн ноцтой байна вэ? Тухайн өвчний тархалтад жендэрийн ялгаа байгаа эсэх? Өвчлөлийн гол шалтгаан нь юу болох (ариун цэвэр, хоол хүнс, хөдөлгөөний идэвхийн байдал зэргийг анхаарах)? Жендэрийн энэхүү ялгаатай байдалд нөлөөлж байгаа нөхөн үржихүйнхээс бусад ямар шалтгаан байна вэ?
- Чиглэсэн хүн амын дунд ажил мэргэжлийн хортой нөхцөл байгаа эсэх? Хортон шавьж, сүлжмэлийн үйлдвэрийн хортой будаг, электроникийн үйлдвэрлэлийн хортой хаягдал зэрэгт өртөж байгаа эсэхийг анхаарах. Үүнд жендэрийн ялгаа байгаа эсэх? Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдэд эрсдэл байгаа эсэх?
- Эмэгтэйчүүдийн ажлын ачаалал хэр байгаа, тэдний дунд тодорхой төрлийн өвчнүүдийг (тэжээлийн доройтол, цус багадалт болон бусад) ажил мэргэжилтэй холбоотой гэж тайлбарладаг эсэх?
- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдалтай холбоотой мэдээлэл байгаа эсэх, түүнийг авч болох эсэх? Өвчний тохиолдолд жендэрийн ялгаа байгаа эсэх?
- Олон нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ямар үүрэгтэй байна вэ?
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүст элбэг тохиолддог өвчнүүдийг хэрхэн тайлбарладаг вэ?
- Хүүхдээ эмнэлэг, эмчилгээнд авч очих тухай шийдвэрийг хэн гаргадаг вэ? Эм худалдаж авах тухай шийдвэрийг хэн гаргадаг вэ?
- Төсөл эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалд анхаарахдаа тэдний эх гэдгийнх нь хувьд чиглэж байна уу? Эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд үйл ажиллагаа чиглүүлэх хэрэгцээ байгаа эсэх?

#### ЗӨВЛӨМЖ

Эх, хүүхдийн

эрүүл мэндэд

эмэгтэйчүүд

эмэгтэйчүүддээ

гэсэн үйлчилгээг

үр дүнтэй

байлгахын

хөхүүлэн дэмж

### Зөв хоололт

- Үйлчилж буй хүн амын өргөн хэрэглэдэг хоол тэжээл нь юу болох? Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд хоол тэжээлийн хүртээмж ялгаатай байдаг эсэх?
- Хүнсээ худалдаж авдаг уу эсвэл өөрсдөө тарьж ургуулдаг уу? Амьжиргаандаа шаардлагатай мөнгө олохын төлөө борлуулдаг бүтээгдэхүүний өөрчлөлт нь хоол хүнсний хангамж болон хооллох хэв маягт нөлөөлж байна уу? Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдалд ямар нэг ялгаа байна уу?
- Эмэгтэйчүүд ихэвчлэн хэдий хугацаанд хүүхдээ хөхүүлдэг? Охид, хөвгүүдийг хөхүүлэх хугацаанд ялгаа байдаг эсэх? Хүүхэд хөхүүлэх талаар соёл заншлын ямар хандлагууд байна вэ? Хүүхдээ угжих нь хэр түгээмэл болох? Хүүхдээ угжихад хүргэж байгаа нийгэм эдийн засгийн ямар хүчин зүйлс байна вэ?
- Жирэмсэн эмэгтэй хүүхдээ хөхүүлж байхыг соёл заншлаараа хүлээн зөвшөөрдөг үү?
- Эмэгтэйчүүдийг жирэмсэн болон хөхүүл байх үед нь хоол хүнсний нарийн дэг журам баримтлах хатуу дүрэм, заншил байдаг эсэх?
- Ижил насны охид хөвгүүдийг өсгөхөд ялгаатай хэв маяг байдаг эсэх? Ялгаатай өвчнүүд байна уу? Эдгээр ялгаа нь тэднийг хооллох өөр өөр хэв маяг болон бусад хүчин зүйлстэй холбоотой эсэх?

---

Эрүүл мэндийн  
анхан шатны  
тусламж  
үйлчилгээний  
эртгийг бууруулах  
замаар ядуу  
эмэгтэйчүүдэд  
илүү хүртээмжтэй  
болгох

---

# НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЖЕНДЭРИЙН АСУУДАЛ

## Гол асуултууд

### Эхийн эрүүл мэндийн эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлс ба эмэгтэйчүүдийн эрүүл мэнд

- Эхийн эндэгдэл тохиолдол хэр байна вэ? Эхийн эрүүл мэндэд гарч буй эрсдэл нөлөөлж буй хүчин зүйлс юу вэ? Эмнэл зүйн, орчны болон нийгэм эдийн засгийн ямар шалтгаанууд зонхилж байна вэ? Аль насны эмэгтэйчүүд хамгийн их эрсдэлтэй байна вэ? Төрөлтийн хичнээн хувь нь мэргэжлийн бэлтгэгдсэн эх баригчийн туслалцааг авч байна вэ?
- Эмэгтэйчүүдийн хүүхэд тээх нас нь хэд вэ?
- Үйлчилж байгаа хүн амын дунд эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн ямар асуудал байна вэ эсвэл эмэгтэйчүүдийн бусад өвөрмөц өвчлөл байна уу?
- Төслийн хэрэгжиж байгаа газарт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл түгээмэл эсэх? Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн болон олон нийтэд тулгуурласан ямар үйлчилгээ байна вэ?
- Хүүхэд эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд (нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрийг оролцуулан) эмэгтэйчүүд-эмэгтэйчүүддээ гэсэн үйлчилгээ байдаг эсэх? Эмэгтэйчүүд эмэгтэйчүүддээ үзүүлэх эх хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ дутагдалтайгаас эмэгтэйчүүд эрүүл мэндийн тусламж авах нь бэрхшээлтэй байна уу?

#### Жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэндийн зарим стратегиуд

- Үйлчлүүлж буй хүн амын дунд эмэгтэйчүүд, хүүхэд, эрэгтэйчүүдийн хоол тэжээлийн сайжруулах чиглэлээр мэдээллийг тараах
- Тухайн төслийг хэрэгжүүлж байгаа газарт хүчирхийллийн асуудал түгээмэл бол эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах. Тухайлбал, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд туслах эрүүл мэндийн төвүүд, хамгаалах байраар үйлчлэх

## Бэлгийн замын халдварт өвчин

- Төсөлд хамрагдаж буй эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн дунд бэлгийн замын халдварт өвчин тулгамдсан асуудал болж байна уу? Тэдгээр тохиолдлуудыг бүртгэх, мэдээлэхэд нийгмийн талаас саад болж байгаа зүйл байна уу? Бэлгийн замын халдварт өвчнөөс хамгаалах арга хэмжээг авахад соёл заншлын холбоотой саад тогтор байгаа эсэх?
- Үйлчилж байгаа хүн амын дунд ХДХВ/ДОХ хэр тархмал байна вэ? Гетеросекс замаар халдварлах нь түгээмэл эсэх?
- ХДХВ/ДОХ –ын халдвар ядуурал болон эмэгтэйчүүдийн бэлгийн амьдрал хоорондоо ямар харилцан хамааралтай вэ?
- Хэрэв ХДХВ/ДОХ эрүүл мэндийн ноцтой асуудал бол тэдгээр өвчтөнг хэн асарч халамжилдаг вэ?

## Гол стратегиуд

### Зорилтууд болон зорилтот бүлгүүд

- Төслийн зорилт нь эрүүл мэндийн тусламжийн хүртээмжийн тэгш бус байдал, эрүүл мэндийн буруу тогтолцоог засах зэрэг асуудлуудыг авч үзэх
  - Төслийн зорилтууд нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээг ялгаатай авч үзэхэд чиглэгдсэн байх ёстой
  - Зөвхөн эхийн эрүүл мэндэд хязгаарлагдмал байдлаар чиглэсэн бус эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд өргөн хүрээтэй хандсан байвал зохино
  - Зорилтот бүлгүүд өөрсдийн эрүүл мэндийн хэрэгцээгээ өөрсдөө тодорхойлж төслийн төлөвлөлтөд оролцсон байвал зохино. Төрийн бус байгууллагууд, олон нийтэд түшиглэсэн байгууллагуудыг мөн оролцуулахыг бодолцох хэрэгтэй.

- Бэлгийн амьдрал, гэрийн ажил, үр хүүхдээ өсгөх зэрэгт эрэгтэйчүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, дэмжих, эмэгтэйчүүдийн хүчирхийллийг бууруулахад тэдний зан байдал, бэлгийн дадал зуршлыг өөрчлөх, амьдралын арга ухаанд сургах замаар ажиллах
- Бэлгийн амьдрал, хүүхэд төрүүлэх, гэрлэх зэрэгт эмэгтэйчүүд өөрсдөө шийдвэр гаргадаг бие даасан байдлыг хөхүүлэн дэмжих

### Тоо баримт цуглуулах

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэнд стандарт, эрүүл мэндийн салбар дахь эрэгтэй\эмэгтэй хүмүүсийн байр суурь, үүрэг, сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын тоо, сургалтын түвшин, эрэгтэй, эмэгтэйг ажилуулах сонирхол илүү байна уу эсвэл эмэгтэйчүүдийг үү, эрүүл мэндийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж түүнээс ашиг хүртэж байгаа талаар хүйсийн ялгаатай тоо баримтыг цуглуулах
- Гэр бүлийн эрүүл мэндийн хэрэгцээ ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар гаргаж байгаа шийдвэрүүд дээр хүйсийн ялгаатай тоо баримт цуглуулах

---

**Зөвхөн эх байх тухай  
бус, эмэгтэйчүүдийн  
эрүүл мэндийн  
асуудалд өргөн  
хүрээтэй хандах нь  
зүйтэй**

---

### Тогтолцоог бэхжүүлэх

- Төслийн хүрээнд эрүүл мэндийн салбарын удирдлага, хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр эмэгтэйчүүдийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг явуулах
- Тосгоны болон олон нийтийн ажилтнууд, эрүүл мэндийн боловсролын ажилтнууд, эмч, эрүүл мэндийн байгууллагуудын удирдагчид, менежерүүд, сувилагч, бага эмч нарыг оролцуулан эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээг үзүүлдэг бүх чиглэлээр сургалтад хамруулах замаар тэдний хэрэгцээнд үндэслэсэн арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэгч агентлагт туслах
- Уламжлалт аргаар эх барьж авдаг хүмүүсийг анагаахын сургалтад хамруулах
- Төсөл хэрэгжиж байгаа бүс нутагт ажиллаж байгаа багш нарыг төсөлдөө хамруулах, хооллох, эрүүл ахуй ариун цэвэр сахих дадал зуршлыг болон гэр бүл төлөвлөлтийн талаар эмэгтэйчүүд, тэдний гэр бүлд хор хохиролтой эсвэл хориотой хандлагыг өөрчлөх санаачлагыг дэмжих.

- Ажилтнууд болон үйлчилгээг үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж өөрчлөх. Эрүүл мэндийн ажилтнуудыг нэгдсэн үйлчилгээг үзүүлдэг болгохоор сурга (жишээ нь гэр бүл төлөвлөлт, аюулгүй үр хөндөлт, хүчирхийлэл, сүрьегийн эсрэг дархлаажуулалт г.м.)
- Жендэрийн мэдрэмжтэй болгох, жендэрийн төлөвлөлт, оролцооны аргын талаар хэрэгжүүлэгч агентлагуудад сургалт явуулах.
- Албан ёсны эрүүл мэндийн тогтолцоо болон хамт олны хооронд итгэлцэл, хамтын ажиллагааг бий болгоход чиглүүлэх. Хамт олон ба эрүүл мэндийн тогтолцооны хамтарсан үйл ажиллагааг дэмжсэн жижиг төслүүдийг хэрэгжүүлж орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээ, сургалтыг сайжруулах
- Эрүүл мэндийн төслийг холбогдох салбар болон бодлоготой холбох Тухайлбал, ус ба эрүүл ахуй, боловсрол, хөдөө аж ахуй г.м.

### Оролцоо

- Эрүүл мэнд болон холбогдох үйлчилгээг сайжруулахын тулд оролцоог нь нэмэгдүүлэхийн тулд эрүүл мэндийн асуудлуудын талаар зорилтот бүлгийн мэдлэгийг дээшлүүлэх. Төрийн бус болон олон нийтэд тулгуурласан байгууллагуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулж болох юм.
- Эмэгтэйчүүдийг төсөлдөө олноор нь хамруулж орон нутгийн эмэгтэй ажиллагсадын дунд тогтсон харилцаа, үйлчилгээг ашиглах. Төслийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд эмэгтэйчүүдийг оролцуулахад төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.
- Төслийн хүрээнд явагдаж байгаа бүх сургалтын арга хэмжээнүүдэд эмэгтэйчүүдийн оролцоог квот тогтоох замаар тэдэнд хүртээмжтэй байлгах.

### Мониторинг ба үнэлгээ

- Хөтөлбөрийг төлөвлөхдөө төслийн үр дүн хүлээж байгаа үр дүнгийн тоон болон чанарын жендэрийн мэдрэмжтэй үзүүлэлтүүдийг боловсруулахыг дэмжих

#### ЗӨВЛӨМЖ

Эмэгтэйчүүдийг  
эрүүл мэндийн  
сургалтанд  
хамруулж,  
оролцооны болон  
олон нийтэд  
тулгуурласан  
тусламж  
үйлчилгээг  
өргөжүүлэх

## ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТ ДЭХЬ ЖЕНДЭРИЙН АСУУДАЛ

### Гол асуултууд

Тусламж  
үйлчилгээг  
авахад ямар  
хүчин зүйлс  
эмэгтэйчүүдэд  
нөлөөлж  
байна вэ?

- Хосууд болон гэр бүлд хүүхэд төрүүлэх тухай асуудлыг хэн шийддэг вэ?
- Хүүхэд гаргах тухай мэдлэг хандлагад хүйсийн ялгаа байгаа эсэх?
- Төрөлтийг хянах уламжлалт ямар аргуудыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс хэрэглэж байна вэ?
- Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг тухайн улсад хуульчилсан байдаг уу? Нас, гэрлэлтийн байдал, хүүхдийн тооноос хамааралгүйгээр жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл эмэгтэйчүүдэд хүртээмжтэй юу? Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэх, үр хөндүүлэхэд эмэгтэйчүүд эрэгтэйгээс зөвшөөрөл авах шаардлагатай юу? Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл ямар үнэтэй вэ? Тэдгээр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст хэр хүртээмжтэй байна вэ?
- Зорилтот хүн амын дунд жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэлийг хэрэглэдэг түвшин нь хэр байна вэ? Жирэмслэлтээс сэргийлэх аргыг жил тутам шинээр хэрэглэдэг хувь хэмжээ нь хэр вэ? Хамгийн өргөн хэрэглэдэг арга нь юу вэ? Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл, сургалтын хөтөлбөр байдаг эсэх? Төслийн хэрэгжиж байгаа газар хэн энэ ажлыг хийж байна вэ – төрийн бус байгууллага уу эсвэл улсын байгууллага уу? Эдгээр сургалт мэдээлэл нь бага боловсролтой хүмүүс зориулагдсан байна уу? Тэдгээр хөтөлбөр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль нэгэнд нь үү эсвэл хоёуланд нь зориулсан байна уу? Тэдгээр аргын давуу болон дутагдалтай талын талаар мэддэг үү?

---

Эрэгтэй, эмэгтэй  
хүмүүст аль алинд нь  
эрүүл мэнд, төрөлтийн  
тухай болон энэ  
талаар хүн амын  
баримтлах стратегийн  
талаар мэдээллийг  
хүргэх

---

- Гэр бүл төлөвлөлтийн талаархи мэдээллийг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд хэр хүлээж авдаг вэ? Тэдгээр мэдээлэл нь тэдний соёл заншилд нь хэр тохиромжтой вэ?
- Гэр бүл төлөвлөлт нь үргүй болгоход чиглэдэг үү? Нийгмийн болон соёл заншлын асуудал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг үргүй болох асуудлуудтай холбоотой юу?
- «Тусламж үйлчилгээний чанар»-ын асуудал гэр бүл төлөвлөлтийг дэмжихтэй холбогдсон эсэх? Тэдгээр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст хэрхэн нөлөөлж байна вэ?
- Үргүйдэл хэр түгээмэл вэ? Ямар бүлгийнхэнд үргүйдэлт зонхилж байна вэ? Үргүйдэлтийн гол шалтгаан нь юу болох, түүний нөлөө?
- Үр хөндөлт (хууль ёсны болон хууль бус) хэр түгээмэл вэ? Үр хөндөлтийг хуульчилсан эсэх? Ямар бүлгүүд илүү анхаарал татахаар байна вэ? Эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд тэр нь хэрхэн нөлөөлж байна вэ?
- Амниоцинтез болон чанд авиан шинжилгээнүүд хүүхдийнхээ хүйсийг мэдсэний үндсэн дээр хийдэг үр хөндөлттэй холбоотой эсэх?
- Гэрлээгүй эмэгтэйчүүд болон «бутач» хүүхдийн талаархи соёл заншлын болон нийгмийн хандлага нь ямар вэ?

---

Эмэгтэйчүүд  
зөвхөн ашиг тусыг нь  
хүртэгч төдийгүй  
шинэчлэгч,  
өөрчлөгч нь мөн

---

### Гол стратегиуд

- Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн харилцааны жендэрийн тусгай стратегийг төлөвлөх
- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд аль аль нь хүлээн зөвшөөрхүйц хөгжлийн болон хүн амын бодлогын стратеги, эрүүл мэнд, төрөлтийн бодлого боловсруулах
- Охид хөвгүүдэд зориулсан хоол тэжээл, эрүүл ахуй, гэр бүл төлөвлөлтийн асуудлаар сургуулийн сургалтын хөтөлбөр, удирдамж зааварчилгаа материал боловсруулах. Хоол тэжээл болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг өсвөр насны охидод олгох нь хожим тэднийг өсч бойжсоны дараа эхийн эрсдлийг бууруулдаг.

Эмнэлгийн  
үйлчилгээний  
цагийн  
гадуур зөвхөн  
эрэгтэйчүүдэд  
зориулсан  
өдөр,  
нөхрүүдэд  
зориулж тусгай  
үйлчилгээг бий  
болгох

- Хоол тэжээл, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаархи төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийг ашиглан өгөхдөө эмэгтэйчүүдэд хүрэхүйц, сонирхолтой байлгах
- Төсөл хэрэгжиж байгаа бүс нутгийн эмэгтэйчүүдийн байгууллага, бүлэг, клуб, сургууль, холбоо, хөршийн холбоо зэрэг байгууллагуудыг оролцуулан аль болох олон эмэгтэйчүүдэд хүрэхийг чармайх.
- Гэр бүлийн эрүүл мэндэд эрэгтэйчүүд эмэгтэйчүүд хариуцлагаа тэнцүү хуваадаг байх талаар мэдээлэл сургалтын үйл ажиллагааг санаачлах
- Төрөлт хоорондын зай, гэр бүлийн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн асуудлаар эрэгтэйчүүдэд чиглэсэн харилцааны стратегийг боловсруулах.
- Эрэгтэйчүүд нөхөр эцгийнхээ хувьд гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн эрүүл мэндийн асуудалд хүлээдэг үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд тэднийг эрүүл мэнд болон гэр бүл төлөвлөлтийн ажилтнууд, олон нийтийн, шашны, төрийн бус байгууллагын манлайлагчдтай хамтарсан ярилцлага хийх аргыг ашиглах.
- Эмнэлэгт зөвхөн эрэгтэйчүүдэд зориулсан өдөр, нөхрүүдэд зориулсан цагийг гаргаж тусгай үйлчилгээг бий болгох
- Гэр бүл төлөвлөлтөд эрэгтэйчүүдийг оролцуулахдаа төрийн бус байгууллагуудын сүлжээг ашиглах
- Нөхөн үржихүйн тогтолцоо, бүтэц, жирэмслэлтээс сэргийлэх арга, техник, давуу болон дутагдалтай талын талаар эрэгтэйчүүд эмэгтэйчүүдэд жендэрийн мэдрэмжтэй, зан заншлынх байдалд зохицуулан мэдээллэх, туслах
- Жирэмслэлтээс сэргийлэхээс гарч болох нөлөө, бэрхшээлүүдийг хяналт тавих талаар эмнэлгийн ажилтнууд хүн амд туслах

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООН ДАХЬ ЖЕНДЭРИЙН АСУУДЛУУД

### Гол асуултууд

- Төсөлд хамрагдах хүн амын доторх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн үйлчилгээ анхан, дунд болон гуравдагч шатанд хэр үр дүнтэй байдаг вэ? Тусламж, үйлчилгээ авахын тулд анхдагч шатыг алгасч шууд гуравдагч шатанд ханддаг уу?
- Шат болгоны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хүмүүст нийгэм-эдийн засгийн ямар хүндрэл бэрхшээл учирдаг вэ? Эмэгтэй, эрэгтэйчүүдийн хооронд тийм ялгаа байдаг уу?
- Эрүүл мэндийн үйлчилгээтэй уялдаа холбоотой /усны хангамж болон ариун цэврийг сайжуулах, бусад өвчинд тавих хяналт/ бусад үйлчилгээ эмэгтэй, эрэгтэйчүүдэд адилхан хүртээмжтэй байдаг уу? Ийм хөтөлбөрүүдийг төлөвлөх, удирдахад эмэгтэй, эрэгтэй хүмүүс хэр идэвхтэй оролцдог вэ?
- Эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд төлөвлөгдөж буй өөрчлөлтүүд жендэрийн харилцааг өөрчлөх үү? Өөрчлөлтүүд эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөх вэ? Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд тэдгээр өөрчлөлтийг хүлээн авах уу?
- Эмнэлгийг болон эмнэлгийн бус эрүүл мэндийн тусламж үйлчилгээний албан ёсны ямар тогтолцоо үйлчлүүлэгч хүн амын дотор байдаг хийгээд эмэгтэйчүүд тэдгээрийг хэр хэрэглэдэг вэ? Эмэгтэй, эрэгтэй хэрэглэгчид тооны хувьд ямар харьцаатай байдаг вэ?
- Эрүүл мэндийн эмэгтэй ажилтнууд олон нийтийн бүлгүүдийн дунд байдаг уу? Тэд ямар үүрэгтэй вэ?
- Төсөл хэрэгжих газарт уламжлалт анагаах ухаан, уламжлалт аргаар эмчлэх хандах явдал нийтлэг үү? Ардын уламжлалт эмчилгээний мэдэгдэхүүн ихэвчлэн эрэгтэйчүүд, эсвэл эмэгтэйчүүдийн чиглэлд байдаг уу? Уламжлалт аргаар эх барьж авдаг эмэгтэйчүүд байдаг уу?

### ЗӨВЛӨМЖ

Эрэгтэйчүүдийг

мөн хамарсан

нийгмийн эрүүл

мэндийн

стратегийг

төлөвлөх

Эмэг-  
тэйчүүдтэй  
холбоотой  
эрүүл  
мэндийн  
ямар  
бэрхшээл  
байдаг вэ?

- Уламжлалт эрүүл мэндийн ямар аргуудыг орон нутгийн хэмжээнд хэрэглэдэг вэ? Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо уламжлалт мэдлэгийг ашигладаг уу? Уламжлалт ойлголт хийгээд практик ажиллагааны аргууд хөтөлбөрт тус дөхөм үзүүлэх үү?
- Эрүүл мэндийн ажилтнаар илүү олон эмэгтэй сургаж бэлтгэх, тохоон томилоход ямар хүндрэл, саад учирдаг вэ?
- Эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж ямар хүчин зүйлээс шалтгаалж багасдаг вэ? Үйлчилгээний цагийн хуваарь, эмэгтэйчүүдийн цаг завгүй байдал, алс хол байрладагаас эмэгтэйчүүд унааны зардалгүй, олон нийтийн газраар зорчих боломжгүй, эмнэлэгт эмэгтэй ганцаарчилсан үзлэгт орох боломжгүй, хүндрэлтэй эсвэл хатуу чанга журам дүрэм, барилга байгууламжийн нөхцөл зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэх.

### Гол стратегиуд

- Уламжлалт эмчилгээний албан болон албан бус хэрэглээ, анагаах ухааны хүртээмжийн талаар жендерийн ялгаатай тоо баримтыг
- Эрүүл мэндийн суурь үйлчилгээг бэхжүүлэхийн тулд эрүүл мэндийн анхдагч шатны тусламж үйлчилгээнд туслахад анхаарал хандуулах
- Гэр бүл төлөвлөлтийн эмнэлэг буюу эрүүл мэндийн төвүүдийг эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байх газруудад байрлуулах, үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарийг нь эмэгтэйчүүдийн ажлын цагт нийцүүлэх
- Эрүүл мэндийн болон холбогдох үйлчилгээг сайжруулахад төсөлд хамрагдах хүн амыг оролцуулахын тулд эрүүл мэндийн мэдлэгийг нь дээшлүүлэх. Эдгээр санал санаачилгад төрийн бус байгууллагууд болон олон нийтэд түшиглэсэн байгууллагуудыг хамруулж болох юм.
- Түргэн тусламжийн тээврийн тогтолцооны хамгийн үр ашигтай арга замууд болон эмэгтэйчүүдийг эмнэлэгт хүргэх олон нийтийн үүргийг бэхжүүлэх

Эмэгтэйчүүдийн болон олон нийтийн байгууллагуудын хоорондын түншлэлийг бэхжүүлэх

- Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний үнийг ядуу хүмүүст бууруулах
- Жендэрийн асуудлууд, ялангуяа хэрэгжүүлэгч агентлаг/ төрийн яамдтай хамтран эмэгтэйчүүд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлээд зогсохгүй эрүүл мэндийн үйлчилгээг хүлээн авагч, эмэгтэйчүүдийг идэвхитэй оролцуулах талаар ярилцах
- Эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн асуудлаар суралцахад туслах, бие биенээ дэмжихэд эмэгтэйчүүдийн бүлэг, сүлжээг хэрхэн хөхиүлэн дэмжих асуудлыг авч үзэх
- Хүмүүсийг сургах, эмэгтэй, эрэгтэйчүүдийг хамтран оролцуулах зэрэг үйлчилгээг хүргэхэд хэрэгжүүлэгч агентлагууд, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болох эсэхийг авч үзэх. Ингэхийн тулд хангалттай санхүүжилтээр хангах.
- Эрүүл мэндийн тогтолцооны бүх түвшинд эмэгтэйчүүдийг үйлчилгээ үзүүлэгчээр сургахад хэрэгжүүлэгч байгууллагууданхаарч, хөрөнгө хүч зориулах нөхцлийг хангах
- Эрүүл мэндийн үйлчилгээний бүх салбарт эмэгтэйчүүдийг олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, эмч, эрүүл мэндийн удирдагч, менежер, сувилагч, эх баригч, туслах ажилтнаар элсүүлэн үйлчилгээний эмэгтэй ажилтнуудын тоог нэмэгдүүлэх шаардлагыг хүлээн зөвшөөрч, үйл ажиллагаа явуулахад хэрэгжүүлэгч агентлагуудад туслах
- Эрүүл мэндэд тулгуурласан үйлчилгээг үзүүлэхэд болон гэр бүл төлөвлөхөд олон нийтийн бүлгүүд, төрийн бус байгууллагуудын үйлчилгээг авч хэрэглэхэд хэрэгжүүлэгч агентлагуудыг хөхиүлэн дэмжих

Эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх тогтолцооны бүх түвшинд эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн ажилтнаар сургах

Гэр бүл төлөвлөлтийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг эмэгтэйчүүдэд ойр газруудад байршуулах

## Шийдвэр гаргагчдад жендэрийн асуудлыг таниулах

- Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн тогтолцооны бүх түвшинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилтнаар эмэгтэйчүүдийг сургах нөхцлийг хангах
- Төслийн албан тушаалд, түүний дотор дотор удирдах албанд томилохоор сургаж бэлтгэх эмэгтэйчүүдийн тоог төсөлд тогтоож өгөх
- Ихэвчлэн эмэгтэйчүүдэд тохиолддог зарим өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ /хүнд ачааг толгой дээрээ зөөж явсанаас нуруу өвдөх, хоол хүнсний дутагдал, олон удаагийн төрөлтөөс цус багадах, зуухны утаа униараас болон жирэмсний үед амралт дутагдсанаас нүд, уушиг өвдөх/нүүдийг хэрэгжүүлэх, дэмжихэд эрүүл мэндийн ажилтнуудыг сургах

### Хайрцаг 3

#### Вьетнамын хүн ам, гэр бүл төлөвлөлт 1994 он

Алс холын уулархаг нутгийн, үндэсний цөөнхийн эмэгтэйчүүдийн хувьд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж бэрхшээлтэй асуудлын нэг байдаг. Эрүүл мэндийн үйлчилгээнд тэдэнд хүргэхэд онцгой хүчин чармайлт тавих шаардлагатай. Вьетнамын Хүн ам, Өрхийн Эрүүл Мэндийн төсөлд мужуудын хүн амын тэн хагасаас илүү хувийг эзэлдэг үндэсний цөөнхийг хамруулсан. Төслийн хүрээнд үзүүлдэг эрүүл мэндийн болон хүн ам төлөвлөлтийн сайжруулсан үйлчилгээг алс хол ууланд нутагладаг тэдгээр үндэсний цөөнхийнхний эмэгтэйчүүдэд хүртээмжтэй болгохын тулд хоёр загвар хөтөлбөрийг туршиж байна. Хамтран ажиллагчдын сүлжээний хамтаар тосгодод эрүүл мэндийн цэгүүдийг байгуулсан бөгөөд шаардлагатай үед, үйлчилгээг суурин газруудад эрүүл мэндийн тусламж үзүүлэхийн тулд тухайн орон нутагт сонгож авсан хамтран ажиллагсдад унадаг дугуй олгосон байна. Тэдэнд нэмэлт болгон үндэсний цөөнхийн дотор эмнэлгийн туслах ажилтнуудыг сургаж бэлтгэсэн байна. Амжилт олсон нөхцөлд хөтөлбөрийг бусад 12 мужид хэрэгжүүлэн, төслийг өргөжүүлж, эрүүл мэнд, гэр бүл

төлөвлөлтийг гүнзгийрүүлэх аж. Эрүүл мэндийн болон хүн ам төлөвлөлтийн эмэгтэй ажилтнуудад эмнэлгийн гүнзгийрүүлсэн сургалт олгож олон тооны эмэгтэйг эрүүл мэндийн ажилтан, сувилагч, эх баригч, эмчийн туслахаар бэлтгэж байна. Үзүүлж байгаа үйлчилгээний талаар мэдлэг бага эмэгтэйчүүдтэй ажиллахын тулд төсөл нийгмийн маркетингийн шинэлэг аргуудыг хэрэглэж, тэдгээр шинэ үйлчилгээг сурталчлахдаа хөдөө газарт олонтаа тохиолддог цайны газрууд гэх мэт уламжлалт бус нээж ажилуулсан. Эх баригч, эмчлэн илааршуулагч гэх мэт олон нийтийн дунд нэр хүндтэй хувь хүмүүс уламжлалт арга барилаар хүмүүсийг илааршуулж эмийн үнийг хямдруулсан. Төслийн үр дүнд вьетнамын олон мянган эх жирэмсний болон төрөлтийн үед эрүүл мэндийн илүү чанартай үйлчилгээнд хамрагддаг болсон аж. Жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэлүүд эрэгтэй, эмэгтэйчүүдэд илүү хүртээмжтэй болсон бөгөөд эрүүл мэнд нь сайжрахын хэрээр тэнд төрөлтийн хоорондох хугацааг зохицуулж, ядуурлаас гарч, илүү бүтээлч амьдралд шилжин орох илүү чадвартай болсон байна.

### КЕЙС СУДАЛГАА

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСЛҮҮДЭД БАРИМТЛАХ ЖЕНДЭРИЙН СТРАТЕГИУД

### Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш бус байдал тэдний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг талаар дүн шинжилгээ хийх, ойлгох

Жендэрийн тэгш бус байдлын талаарх өөрөөр хэлбэл эрэгтэй, эмэгтэй хүйсийн ялгаанаас шалтгаалан хүмүүсийн эрүүл мэндэд учирдаг эрсдэл, тэдний эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн хэлбэрээр илэрдэг нийгэм эдийн засаг, соёлын харилцан адилгүй үр дагаварыг зөв ойлгосноор жендэрийн асуудлыг бодлогод нэгтгэх нь чухал.

### Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн тогтолцоонд илэрдэг жендэрийн тэгш бус байдлыг шийдвэрлэх нь

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийн тогтолцоонд жендэрийн асуудлыг оруулж амжилттай хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдээс харахад жендэрийн тэгш бус байдлыг шийдвэрлэх, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэргийг анхаарах хэрэгтэй. Үйлчилгээ байхгүй, эсвэл хүртээмж хомсдсон төдийгөөр бус эмэгтэйчүүдийн ажлын хүнд хүчир ачаалал, орлого хомсдох, гэр бүлийнхэн нь тэдний эрүүл мэндэд хөрөнгө оруулахыг үл хүсэх, соёлын хандлага гэх мэт нийгэм эдийн засгийн болон соёлын бусад хүчин зүйлээс шалтгаалан эмэгтэйчүүдийн оролцоо хязгаарлагдмал болдог.

Түүнчлэн барилга байгууламж барих, эм үйлдвэрлэх, ажилтнуудыг сургах замаар эрүүл мэндийн тогтолцоог сайжруулдаггүй харин хүртээмжийг сайжруулж, хэрэглэгчдэд хандсан эрүүл мэндийн тогтолцоог өөрчлөн зохион байгуулж, шинээр бий болгосноор энэ бүгдийг хэрэгжүүлэх боломжтой билээ. Эмэгтэйчүүд урьдчилан сэргийлэх болон

Олон нийт болон  
эрүүл мэндийн  
тогтолцооны  
хамтын ажиллагааг  
хэрэгжүүлэх нь

эмчлэн анагаах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өрхөд үзүүлээд зогсохгүй урьдчилан сэргийлэхийн ач холбогдолыг нь ухуулан таниулах үүрэг гүйцэтгэдэгийг төлөвлөгч нар ойлговол зохино. Эмэгтэйчүүд нь хөгжлийн үйл ажиллагааны үр ашгийг хүртэгчид төдийгүй аливаа өөрчлөлтийг хэрэгжүүлэгч гэж тооцогддог.

### Эмэгтэйчүүдийг оролцуулан бүх хамтран ажиллагсадтайгаа зөвлөлдөн, эмэгтэйчүүдийн байгууллагуудтай түншлэлээ бэхжүүлэх нь

Хамтран ажиллагсадтайгаа зөвлөлдөх нь асуудлыг сайн ойлгох тэгсэнээр, эрэлт хэрэгцээг сайн тодорхойлоход тустай учир нэн чухал. Зөвлөлдөх, болон ярилцлагыг ил тод, хүчин төгөлдөр, итгэл даахуйц болгохоос гадна зөвшилд хүрэхэд дөхөм үзүүлдэг. Энэхүү үйл явц нь эрүүл мэндийн болон эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд нөлөөлдөг жендэрийн тэгш бус байдлыг шийдвэрлэхэд талар олон нийтийн ойлголтыг дээшлүүлнэ. Бүх түвшний оролцогчдыг тодорхойлж, эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь чухал. Эмэгтэйчүүдийн байгууллагууд энэ талаар чухал үүрэг гүйцэтгэж чадна.

### Үндэсний чадавхийг бэхжүүлэхэд жендэрийн тэгш байдлыг хөгжүүлэх нь

Бүх газрууд /төрийн болон төрийн бус байгууллага, эмэгтэйчүүдийн байгууллагууд/-д, бүх түвшинд /орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд/ чадавхийг бэхжүүлэх шаардлагатай. Үндэсний бодлого боловсруулах, салбарын хэмжээний хөтөлбөрүүдийн менежмент, удирдлагаас эхлээд хүний нөөцийн төлөвлөлт, үйлчилгээнд үзүүлэх, удирдлагын мэдээллийн тогтолцоо, иргэний нийгэмтэй зөвлөлдөхийг дэмжих хүртэл бүх түвшинд, төрөл бүрийн ажиллагаанд чадавхийг хөгжүүлэх шаардлагатай. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд үйлчилгээг чиглүүлэх, өөрчлөлтийг бүх түвшинд хөтлөн удирдах чадавхи чухал юм. Хамгийн дээд түвшний шийдвэр гаргагчдад жендэрийн тэгш байдлын зорилтуудыг танилцуулж, бүх оролоцгчтой харилцан ярилцах шаардлагатай.

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээ харилцан адилгүйг хүлээн зөвшөөрөх

### Хайрцаг 4

#### Хот суурингийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний Бангладешийн төсөл 1997 он

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд тавих анхаарлыг жирэмслэлт болон төрөлттэй холбоотой томоохон асуудлуудад чиглүүлэх ёстой. Сэтгэл түгшээх өөр асуудал ч бий. Жишээ нь эрүүл мэндэд томоохон бэрхшээл үүсгэдэг гэр бүлийн хүчирхийллийг эрүүл мэндийн төслүүдээр дамжуулан шийдэж эхлээд байна. Жишээ нь Бангладешид хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд туслах тодорхой арга хэмжээг төсөлд тусгадаг. Бангладешид эмэгтэйчүүдийн үхлийн 25 хувь нь эхчүүдтэй холбоотой, бараг 29 хувь нь хүн амины буюу хүчирхийллээс үүсдэг бөгөөд хүн амины нуугдмал хэргүүд ч үүнд багтдаг. 100000 төрөлт тутам 550 эхийн эндэгдэл гардаг нь тус улсыг эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс илүү цөөн орны тоонд оруулдаг аж. Эхийн эндэгдэл өндөр хувьтай байгаад эмнэлгийн үйлчилгээ шаардлагын түвшинд хүрэхгүй явдал нөлөөлдөг боловч жендэрийн тэгш бус байдал энд их нөлөөлдөг. Тухайлбал өсвөр насны охид, залуу эхчүүдийн дотор хоол тэжээлийн дутагдал их байдгаас 70 хувь нь цус багадалттай, эрэгтэйчүүдэд олддог эрүүл мэндийн суурь үйлчилгээ эмэгтэйчүүдэд олддоггүй, гэр оронд болон олон нийтийн дунд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл их гэх мэт бусад хүчин зүйлсийг мөн дурдах ёстой. Төслийн үр ашгийг хүртэгчдийн 75-аас илүү хувийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд хүчирхийллийн золиос болсон эмэгтэйчүүдэд туслах

КЕЙС  
СУДАЛГАА

явдал төслийн чухал бүрэлдэхүүн аж. Дөрвөн хотод байгуулагдсан эрүүл мэндийн төвүүд хүчирхийлэлд өртөгчдөд эмнэлгийн тусламж, хууль зүйн зөвлөгөө өгөхөөс гадна хамгаалах байраар үйлчилдэг. Хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгах ур чадварыг эрүүл мэндийн төвийн ажилтнуудад олгодог. Хүчирхийллийг таслан зогсоох, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруушаах ухамсарыг дээшлүүлэх олон нийтийн сургалтын кампанит ажил ч төсөлд багтаж байгаа. Эмэгтэйчүүдийг үйлчилгээнд хамруулахын тулд эрүүл мэндийн байгууллагууд тэдэнд тохиромжтой цагт буюу орой үдэш, долоо хоногийн эцэс, баярын болон амралтын өдрүүдээр нээлттэй байдаг. Эмнэлгийн байгууллагууд эмэгтэй өвчтөнүүдийн нууцыг хадгалах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаардаг бөгөөд, урьдчилан сэргийлэх болон эмчлэн эрүүл мэндийн үйлчилгээнүүд түүний дотор дархлаажуулалт, хоол тэжээлийн бичил элементүүд, хүн ам төлөвлөлт, төрөхийн өмнөх болон суурь эмчилгээ, эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн сургалт явуулдаг. Эрүүл мэндийн анхдагч шатны тусламж, үйлчилгээг өрхөд илүү хүртээмжтэй болгосноор эмэгтэйчүүд өвчтэй хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүдээ асрахаар ажлаас хөндийрдэг хугацааг төсөл бууруулж, тэдэнд шууд бусаар ашиг тусаа өгдөг байна.

Хавсралт

## ЖЕНДЭРИЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

ТБТТ-ний мэдээ баримт цуглуулах  
Анхдагч Нийгмийн Үнэлгээ /НАҮ/

- Ядуурлын байдал, эрүүл мэндийн салбарын жендэрийн асуудлыг тодорхойлон дүн шинжилгээ хийж, ядуурлыг хамгийн эрчимтэй бууруулах эрүүл мэндийн салбарын арга замуудыг санал болгох.
- Хүн амын чухам аль хэсгийг зорилтот бүлгээ болгохоо сонгож, тодорхойлох, жендэрийн ялгаатай мэдээллийг цуглуулах, эрүүл мэндийн тусламжийн хүртээмж, эрүүл мэндийн байдал зэрэгт жендэрийн ялгаа байгаа эсэхийг анхаарч үзэх
- Хүн амын дэд бүлгүүдийн ялгааг тодруулах, эдгээр бүлгүүдийн дотор эрүүл мэндийн байдал болон эрүүл мэндийн тусламжийн байгууллагад хүрэх боломж талаар ялгаа байгаа эсэхийг тодруулах
- Мэдлэг, хандлага, дадлага, үүрэг, бэрхшээл, хэрэгцээ, эрүүл мэндийн салбарын эн тэргүүний асуудлуудад жендэрийн ялгаа байгаа эсэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг нягтлах
- Зорилтот хүн амд тухайн төслийн хэрэгцээ юу болох: үүнд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн хэрэгцээ ялгаатай эсэх, тэр ялгаа нь төсөлд хэрхэн нөлөөлөх талыг анхаарах
- Чадварыг нь тодорхойлох. Эрэгтэй, эмэгтэй хүмүүст төсөлд хэрхэн оролцох тэдний сонирхол, мэдлэг, чадвар, зохион байгуулалтын нөөц нь юу болох – төсөл нь тэдний нийгмийн соёл заншилтай нь хэрхэн тохирох; Эрүүл мэндийн төсөлд эрэгтэй эмэгтэй хүмүүсийг оролцоход саад болж болох зүйлс (төлбөр, жендэрийн үүрэг, хариуцлага г.м.)
- ТБТТ-ийн явцад болон төслийн хэрэгжилтэд хамтран ажиллах төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтэд тулгуурласан байгууллагууд, эмэгтэйчүүдийн бүлгүүдтэй холбоо тогтоох, тэдний чадавхийг нь үнэлэх
- Шаардлагатай бол холбогдох хууль эрхийн болон бодлогын хүрээг тодорхойлох (үр хөндөлтийн хууль, гэрлэлтийн хууль, г.м.)
- Дүн шинжилгээнд тулгуурлан жендэрийн мэдрэмжтэй, оролцооны төслийг төлөвлөж салбарын цаашдын боломжтой бөгөөд

ТБТТ дахь нийгмийн дүн шинжилгээ  
болон төлөвлөлт

- шаардлагатай бол бодлогын болон салбарын шинэчлэлийг төлөвлөх
- Жендэрийн хяналт, шинжилгээ үнэлгээний механизм, үзүүлэлтийг гаргах
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүс төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд оролцож, зөвлөж байх нөхцлийг хангах
- Жендэрийн дүн шинжилгээг хийх:
  - Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэнд, тэдний эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйлс, тэдний хоорондын ялгаа, ядууралд өртөх эрсдэл эмэгтэйчүүдэд их байдаг байдал, соёлын практик, хөдөлмөрийн хуваарь, ажлын өдрийн ачаалал, үргэлжлэх хугацаа гэх мэтийг тодорхойлох,
  - Өрх болон олон нийтийн дунд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох.
  - Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж дэх ялгааг тодорхойлох.
  - Эрүүл мэндийн тогтолцооны /хөрөнгө хүч, хандлага, ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн болон байгууллагуудын тооны дүн шинжилгээ гэх мэт/ хандлагад дүн шинжилгээ хийх
- Төлөвлөж буй ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо болон төслийн удирдлага дахь тэдний төлөөллийн хувьд санал болгож буй тогтолцооны болон зохион байгуулалтын хүрээг нягтлах
- Томоохон зорилтот бүлгүүд, ялангуяа ядуусын хүртээмж, оролцоог нэмэгдүүлэх төслийн чадавхийг нэмэгдүүлэх.
- Эмэгтэйчүүдийн оролцоо, тэднийг чадваржуулах явдлыг тодорхойлох жендэрийн ялгаатай мэдээллийг цуглуулах, төлөвлөж буй мониторинг болон үнэлгээний тогтолцоо зохистой эсэхийг үнэлэх.
- Эмэгтэйчүүдийн болон жендэрийн асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг нягтлах
- Эмэгтэйчүүд төсөлд оролцож, түүнийн үр ашгаас хүртдэг байх нөхцлийг хангахын тулд төслийн төлөвлөлтөд тусгах тодорхой стратеги болон үйл ажиллагаануудыг бий болгох.

## Эх сурвалжийн түүвэр

Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг 1997. *Жендэр ба Хөгжлийн гарын авлага*

Бридж, 1998. *Жендэр, ДОХ дамжих, нөлөөлөл: Асуудлууд болон баримт*. Олон улсын Хөгжлийн судлал.

Олон Улсын Гэр Бүлийн Эрүүл Мэнд. 1998. *Эмэгтэйчүүдийн Сонголт, Эмэгтэйчүүдийн ахуй: Гэр бүл Төлөвлөлтийн үр нөлөө*. Эмэгтэйчүүд Судлалын төслийн үр дүнгээс.

\_\_\_\_\_. 1998. *Эрэгтэйчүүд ба Нөхөн Үржихүйн Эрүүл Мэнд Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллага, Хөгжлийн Туслалцааны Хороо, 1999, С-21 зорилтонд хүрэх нь: Жендэрийн Тэгш байдал ба Эрүүл Мэнд, Дугаар 2*

Шведийн Олон Улсын Хөгжлийн Байгууллага 1997. *Бодлого хөтөлбөрт тусгах нь гарын авлага. Эрүүл мэнд дэх жендэрийн асуудал*

Их Британы Олон Улсын Хөгжлийн Агентлаг 1997. *Сургамж: 12 жилийн хугацаанд хэрэгжсэн эхчүүдийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн үр нөлөө*  
Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага. 1998. *'Жендэр ба Эрүүл Мэнд'.* Техникийн туслалцааны баримт бичиг  
\_\_\_\_\_. 1998. *Дэлхийн Эрүүл Мэндийн тайлан*

